

# АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК

## САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн аудитын тайлан

Аудитын код: ХӨА-2024/242/НА-СТА-ТЗШ

Цахим хуудас:  
[www.audit.mn](#)

Хөвсгөл аймаг  
2024 он

Аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: А.Эрдэнэбаатар  
Утас: 88883317 Цахим хаяг: [erdenebaatara@audit.gov.mn](mailto:erdenebaatara@audit.gov.mn)

Аудитын менежер: Б.Тэгшдэлгэр  
Утас: 99089114 Цахим хаяг: [tegshdelgerb@audit.gov.mn](mailto:tegshdelgerb@audit.gov.mn)

Ахлах аудитор: Г.Ичинхорлоо  
Утас: 88012671 Цахим хаяг: [ichinkhorlooga@audit.gov.mn](mailto:ichinkhorlooga@audit.gov.mn)

Ари файнэнс аудит ХХК-ийн захирал Д.Ариунаа  
Утас: 99088151 Цахим хаяг: [arifin.audit@gmail.com](mailto:arifin.audit@gmail.com)

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

АЗДТГ-ын байр, А корпус 3 давхар,  
Мөрөн сум, Хөвсгөл аймаг, 67120  
Утас/факс: 7038 3793, Цахим шуудан: khuvsugul@audit.gov.mn  
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.23 № 01/68  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -Т

ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЦАГААННУУР  
СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН  
ЭРХЛЭГЧ Т.ЦЭНДМАА ТАНАА

**Хараат бус аудиторын дүгнэлт**

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Гүйцэтгэлээр тогтмол зардлаас бусад зардлыг улсын төсвөөс, тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлсэн ба улсын төсвөөс 462,203.1 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч 108,870.7 мянган төгрөгийн зарцуулаагүй үлдэгдэлтэй, орон нутгийн төсвөөс 31,000.0 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авч зарцуулаагүй үлдэгдэл 4.9 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

**Аудитын гол асуудал**

Аудитаар төсвийг зохистой удирдаж ажиллаагүйгээс тайлант онд ажиллагсадтай холбоотой авлага, өглөг үүсгэсэн 1,337.6 мянган төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан 7,679.6 мянган төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлсэн, мөн зориулалт бусаар зарцуулсан 1,105.5 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоов.

**Бусад асуудлын хэсэг**

Цагааннуур сумын Засаг даргатай байгуулсан 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө 94.7 хувийн гүйцэтгэлтэй дүгнэгдсэн байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

5724041105

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР





ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АКТ

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 31/22270439/20.А-2024/  
242/АА-СНА-ТЗШ

Мөрөн сум

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд зориулалт бусаар /Ойн хандив цуглуулах, цасны баяр, Хөвсгөл нуур явах/ 1,105,500 (нэг сая нэг зуун таван мянга таван зуу) төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байгаа ба Эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагын албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.2.3.8 "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 т заасан бусад нөхцөл байдал үүссэн" гэсэн заалтуудыг үндэслэн **ТОГТООХ нь:**


1. Тайлант онд зориулалт бусаар зарцуулсан шатахууны үнэ 1,105,500 (нэг сая нэг зуун таван мянга таван зуу) төгрөгийг Хөвсгөл аймгийн төрийн санд байрших 100170000955 тоот /Хө. Бусад нэр заагдаагүй орлого/ дансанд төвлөрүүлэх;
2. Актын биелэлтийг 2024 оны 09 дугаар сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газарт<sup>1</sup> нотлох баримтын хамт ирүүлэхийг Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Т.Цэндмаа, нягтлан бодогч С.Отгонжаргал нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  А.ЭРДЭНЭБААТАР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Л.ПУНСАЛ-ОРЛОМ



<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, аймгийн ЗДТГ-ын байрны 3 дугаар давхар, Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газрын 302, тоот Утас:70384043

6724020103

8.9.1-д заасны дагуу Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр



ХӨВСГӨЛ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 02 сарын 26 өдөр

№ 14/А2270439/ХӨА-2024/  
242/НА-СТА-ТЗШ

Мөрөн сум

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, эдийн засгийн ангилал зөрчин зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан болон Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой нийт 399,732,407.84 /Гурван зуун ерэн есөн сая долоон зуун гучин хоёр мянга дөрвөн зуун долоон төгрөг наян дөрвөн мөнгө/ төгрөгийн 2 зөрчил илэрсэн. Үүнд:

1. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд 4 мэдээлэл буюу Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт- эдийн засгийн ангиллаар, Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалтаар, Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан, хагас жилийн санхүүгийн тайлан гэсэн мэдээллүүдийг хугацаа хоцроож мэдээлсэн, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш орлогын 25 гүйлгээний 386,473,300 төгрөгийн, зарлагын 1 гүйлгээний 5,579,550 төгрөгийн, нийт 392,052,850 төгрөгийн мэдээлэл мэдээлээгүй байна.
2. Ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардал руу зардлын бүлэг хооронд 617,657.84 төгрөгийг гүйлгэн зарцуулсан, Бараа үйлчилгээний бусад зардлаас эдийн засгийн ангилал зөрчин байгууллагын эзэмшлийн автомашин байхгүй байж 7,061,900 төгрөгийн шатахуун зарцуулсан.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5.4-т "улсын төсвийн хэмнэлт, хэтрэлт, түүний шалтгааны тайлбарыг улирал бүр", 6.1.2-т "хагас жилийн төсвийн гүйцэтгэлийг жил бүрийн 08 дугаар сарын 15-ны өдрийн дотор", 6.1.5-д "төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн багцад хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эхээр нь тухайн жилийн 04 дүгээр сарын 25-ны өдрийн дотор, аудитын тайлан, дүгнэлтэд тусгагдсан асуудлаар авч хэрэгжүүлсэн арга хэмжээг тухайн жилийн 07 дугаар сарын 01-ний өдрийн дотор" гэсэн заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд "Нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, акт тогтоох журмын 4.2.1.11-т "Хууль, тогтоомж, гэрээ, хэлцэл, зөрчсөн алдаа зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал нь албан шаардлага өгөх нөхцөл болно" гэж заасныг тус тус үндэслэн **ШААРДАХ** нь:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, хуулийн хугацаанд мэдээллийг бүрэн, үнэн зөв мэдээлэх, зөрчлийг таслан зогсоох;

6724030045

хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

2. Батлагдсан төсвийг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулах, зөрчлийг таслан зогсоох;
3. Албан шаардлагын биелэлтийг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрийн дотор Хөвсгөл аймаг дахь Төрийн аудитын газар<sup>1</sup>т нотлох баримтыг хамт ирүүлэхийг Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн эрхлэгч Т.Цэндмаа, нягтлан бодогч С.Отгонжаргал нарт даалгав.


**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

А.ЭРДЭНЭБААТАР

АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН  
АУДИТОР

Л.ПУНСАЛ-ОРЛОМ



<sup>1</sup> Хөвсгөл аймаг, Мөрөн сум, 8-р баг, Хөвсгөл аймгийн ЗДТГ-ын байр 3 давхар 302 тоот

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

| Дансны код  | Балансын үзүүлэлт   | Эхний үлдэгдэл        | Эцсийн үлдэгдэл       |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>  | <b>157,887,619.15</b> | <b>205,463,263.75</b> |
| <b>31</b>   | <b>МӨНГӨН ХӨРӨНГӨ</b>   | 64,709,618.20         | 108,870,677.10        |
| <b>312</b>  | <b>Банкинд байгаа бэлэн мөнгө</b>                                     | 64,709,618.20         | 108,870,677.10        |
| <b>3121</b> | <b>Төгрөг</b>   | 64,709,618.20         | 108,870,677.10        |
| 31211       | Төрийн сангийн харилцах   | 64,709,618.20         | 108,870,677.10        |
| <b>33</b>   | <b>АВЛАГА</b>   | 5,096,243.16          | 1,208,088.86          |
| 33100       | Ажиллагчидтай холбогдсон авлага                                       | 5,096,243.16          | 1,208,088.86          |
| <b>35</b>   | <b>БАРАА МАТЕРИАЛ</b>   | 88,081,757.79         | 95,384,497.79         |
| <b>351</b>  | <b>Түүхий эд материал</b>   | 64,900.00             | 413,000.00            |
| 35130       | Эм боох материал  | 64,900.00             | 413,000.00            |
| <b>354</b>  | <b>Хангамжийн материал</b>  | 88,016,857.79         | 94,971,497.79         |
| 35410       | Бичиг хэргийн материал  | 3,139,655.00          | 421,500.00            |
| 35420       | Аж ахуйн материал   | 44,833,633.43         | 50,525,733.43         |
| 35440       | Түлш, шатах тослох материал   | 7,956,000.00          | 8,472,375.00          |
| 35460       | Хүнсний материал  | 9,083,270.00          | 12,547,590.00         |
| 35470       | Бусад хангамжийн материал   | 23,004,299.36         | 23,004,299.36         |
| <b>2</b>    | <b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>                                    | <b>359,632,401.95</b> | <b>328,612,524.03</b> |
| <b>39</b>   | <b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>   | 359,632,401.95        | 328,612,524.03        |
| <b>392</b>  | <b>Биет хөрөнгө</b>   | 332,450,672.03        | 301,649,414.19        |
| 39201       | Барилга, байгууламж, орон сууц  | 315,239,904.31        | 315,239,904.31        |
| 39202       | Хуримтлагдсан элэгдэл   | -62,846,916.53        | -76,679,923.77        |
| 39205       | Машин тоног төхөөрөмж (компьютер)                                     | 69,294,274.00         | 69,294,274.00         |
| 39206       | Хуримтлагдсан элэгдэл   | -19,127,538.96        | -33,000,527.08        |
| 39207       | Тавилга, аж ахуйн эд хогшил   | 36,348,984.63         | 38,126,984.63         |
| 39208       | Хуримтлагдсан элэгдэл   | -11,068,234.38        | -15,141,496.82        |
| 39214       | Бусад үндсэн хөрөнгө  | 2,400,000.00          | 2,400,000.00          |
| 39215       | Хуримтлагдсан элэгдэл   | -800,000.04           | -1,600,000.08         |
| 39217       | Ном   | 3,010,199.00          | 3,010,199.00          |
| <b>393</b>  | <b>Биет бус хөрөнгө</b>   | 27,181,729.92         | 26,963,109.84         |
| 39301       | Програм хангамж   | 1,024,350.00          | 1,024,350.00          |
| 39302       | Хуримтлагдсан элэгдэл   | -218,620.08           | -437,240.16           |
| 39303       | Бусад биет бус хөрөнгө  | 26,376,000.00         | 26,376,000.00         |
| <b>3</b>    | <b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>                                    | <b>517,520,021.10</b> | <b>534,075,787.78</b> |
| <b>4</b>    | <b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>   | <b>180,341.15</b>     | <b>129,492.00</b>     |
| <b>41</b>   | <b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>                                      | 180,341.15            | 129,492.00            |
| <b>413</b>  | <b>Өглөг</b>  | 180,341.15            | 129,492.00            |
| 41310       | Ажилчидтай холбогдсон өглөг   | 60,991.00             | 129,492.00            |
| 41320       | Бараа үйлчилгээний зардлын өглөг                                      | 119,350.15            | 00.00                 |
| <b>5</b>    | <b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>                                       | <b>517,339,679.95</b> | <b>533,946,295.78</b> |
| <b>51</b>   | <b>Засгийн газрын хувь оролцоо</b>                                    | 517,339,679.95        | 533,946,295.78        |
| 511         | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 41,903,171.00         | 41,903,171.00         |
| 51101       | Өмч: - төрийн   | 41,903,171.00         | 41,903,171.00         |
| <b>512</b>  | <b>Хуримтлагдсан үр дүн</b>   | 180,195,355.30        | 196,801,971.13        |
| 51210       | Өмнөх үеийн үр дүн  | 103,308,535.55        | 103,308,535.55        |
| 51220       | Тайлант үеийн үр дүн  | 76,886,819.75         | 93,493,435.58         |
| 51300       | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү                                      | 295,241,153.65        | 295,241,153.65        |

|   |  |                       |                       |
|---|--|-----------------------|-----------------------|
| 6 | <b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН<br/>VI=IV+V</b> | <b>517,520,021.10</b> | <b>534,075,787.78</b> |
|---|--|-----------------------|-----------------------|

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>                                      | <b>456,327,508.00</b> | <b>503,546,100.00</b> |
| <b>12</b>   | <b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>  | <b>39,023,108.00</b>  | <b>10,343,000.00</b>  |
| <b>120</b>  | <b>Нийтлэг татварын бус орлого</b>  | 39,023,108.00         | 10,343,000.00         |
| 120004      | Төсөв байгууллагын өөрийн орлого  | 39,023,108.00         | 10,343,000.00         |
| 1200045     | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого   | 39,023,108.00         | 10,343,000.00         |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>  | <b>417,304,400.00</b> | <b>493,203,100.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>  | 373,139,400.00        | 462,203,100.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт   | 373,139,400.00        | 462,203,100.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                                       | 44,165,000.00         | 31,000,000.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллаг           | 44,165,000.00         | 31,000,000.00         |
| <b>2</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>  | <b>379,440,688.25</b> | <b>486,939,484.17</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>379,440,688.25</b> | <b>486,939,484.17</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                                      | 378,775,688.25        | 486,934,577.07        |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                                    | 241,308,114.00        | 307,856,258.40        |
| 210101      | Үндсэн цалин  | 241,308,114.00        | 200,196,062.40        |
| 210102      | Нэмэгдэл  | 00.00                 | 97,188,744.00         |
| 210104      | Урамшуулал  | 00.00                 | 10,471,452.00         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>                       | 31,695,182.61         | 39,171,148.00         |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 22,023,473.61         | 27,185,426.00         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 2,413,081.00          | 3,078,562.00          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 1,957,344.00          | 2,354,761.00          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 475,122.00            | 665,495.00            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 4,826,162.00          | 5,886,904.00          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                            | 11,013,382.55         | 15,359,355.75         |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 4,011,808.15          | 4,030,252.75          |
| 210302      | Түлш, халаалт   | 5,260,532.40          | 9,771,625.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 1,741,042.00          | 1,557,478.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 45,300,890.00         | 51,694,370.00         |
| 210501      | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл   | 00.00                 | 167,900.00            |
| 210502      | Хоол, хүнс  | 45,300,890.00         | 51,526,470.00         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                                    | 5,382,500.00          | 13,538,250.00         |
| 210604      | Урсгал засвар   | 5,382,500.00          | 13,538,250.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | 426,700.00            | 852,900.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 426,700.00            | 852,900.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | 43,648,919.09         | 58,462,294.92         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 9,509,566.50          | 16,784,217.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 4,377,100.00          | 8,880,200.00          |
| 210903      | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол  | 29,762,252.59         | 32,797,877.92         |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | 665,000.00            | 4,907.10              |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | 665,000.00            | 4,907.10              |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 665,000.00            | 4,907.10              |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>                                   | <b>76,886,819.75</b>  | <b>16,606,615.83</b>  |
| <b>5</b>    | <b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>  | <b>76,886,819.75</b>  | <b>16,606,615.83</b>  |

### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт                              | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|---------------------------------------|---------------------------------|-----------------------|-------------------|---|
| C01 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 41,903,171.00                   | 295,241,153.65        | 103,308,535.55    | 440,452,860.20                          |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 41,903,171.00                   | 295,241,153.65        | 103,308,535.55    | 440,452,860.20                          |
| C07 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | 76,886,819.75     | 76,886,819.75                           |
| C08 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 41,903,171.00                   | 295,241,153.65        | 180,195,355.30    | 517,339,679.95                          |
| D01 | 2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 41,903,171.00                   | 295,241,153.65        | 180,195,355.30    | 517,339,679.95                          |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл            | 41,903,171.00                   | 295,241,153.65        | 180,195,355.30    | 517,339,679.95                          |
| D08 | Тайлант үеийн үр дүн                  | 00.00                           | 00.00                 | 16,606,615.83     | 16,606,615.83                           |
| D09 | 2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 41,903,171.00                   | 295,241,153.65        | 196,801,971.13    | 533,946,295.78                          |

### 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код  | Үзүүлэлт  | Өмнөх оны гүйцэтгэл   | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-----------------------|-----------------------|
|             | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                               |                       |                       |
| <b>1</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>                       | <b>417,304,400.00</b> | <b>493,203,100.00</b> |
| <b>13</b>   | <b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>                                | <b>417,304,400.00</b> | <b>493,203,100.00</b> |
| <b>1310</b> | <b>Улсын төвлөрсөн төсвөөс</b>                                      | 373,139,400.00        | 462,203,100.00        |
| 131001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт                                   | 373,139,400.00        | 462,203,100.00        |
| <b>1320</b> | <b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>                               | 44,165,000.00         | 31,000,000.00         |
| 132001      | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 44,165,000.00         | 31,000,000.00         |
| <b>2</b>    | <b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>                        | <b>352,594,781.80</b> | <b>449,042,041.10</b> |
| <b>21</b>   | <b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>  | <b>352,594,781.80</b> | <b>449,042,041.10</b> |
| <b>210</b>  | <b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>                              | <b>351,929,781.80</b> | <b>449,037,134.00</b> |
| <b>2101</b> | <b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>                            | 246,855,076.47        | 304,588,715.94        |
| 210101      | Үндсэн цалин  | 195,699,605.77        | 200,196,060.41        |
| 210102      | Нэмэгдэл  | 38,332,907.49         | 93,921,204.19         |
| 210104      | Урамшуулал  | 12,822,563.21         | 10,471,451.34         |
| <b>2102</b> | <b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>               | 31,187,005.33         | 38,482,035.16         |
| 210201      | Тэтгэврийн даатгал  | 21,508,207.40         | 26,636,728.74         |
| 210202      | Тэтгэмжийн даатгал  | 2,376,263.28          | 2,895,485.15          |
| 210203      | ҮОМШӨ-ний даатгал   | 1,985,886.61          | 2,536,879.89          |
| 210204      | Ажилгүйдлийн даатгал  | 469,813.64            | 569,474.73            |
| 210205      | Эрүүл мэндийн даатгал   | 4,846,834.40          | 5,843,466.65          |
| <b>2103</b> | <b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>                    | 16,000,000.00         | 15,995,092.90         |
| 210301      | Гэрэл, цахилгаан  | 3,892,458.00          | 6,237,602.90          |
| 210302      | Түлш, халаалт   | 9,984,000.00          | 8,200,000.00          |
| 210303      | Цэвэр, бохир ус   | 2,123,542.00          | 1,557,490.00          |
| <b>2105</b> | <b>Нормативт зардал</b>   | 42,051,300.00         | 54,990,790.00         |
| 210502      | Хоол, хүнс  | 42,051,300.00         | 54,990,790.00         |
| <b>2106</b> | <b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>                            | 5,000,000.00          | 15,000,000.00         |

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|             |   |                      |                       |
|-------------|---|----------------------|-----------------------|
| 210604      | Урсгал засвар   | 5,000,000.00         | 15,000,000.00         |
| <b>2108</b> | <b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>             | 426,700.00           | 852,900.00            |
| 210806      | Мэдээлэл, технологийн үйлчилгээ   | 426,700.00           | 852,900.00            |
| <b>2109</b> | <b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>                                      | 10,409,700.00        | 19,127,600.00         |
| 210901      | Бараа үйлчилгээний бусад зардал   | 8,159,700.00         | 16,569,000.00         |
| 210902      | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх   | 2,250,000.00         | 2,558,600.00          |
| <b>213</b>  | <b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>   | <b>665,000.00</b>    | <b>4,907.10</b>       |
| <b>2134</b> | <b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b> | 665,000.00           | 4,907.10              |
| 213403      | Төвлөрүүлэх шилжүүлэг   | 665,000.00           | 4,907.10              |
| <b>3</b>    | <b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>                     | <b>64,709,618.20</b> | <b>44,161,058.90</b>  |
| <b>7</b>    | <b>САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>                      | <b>00.00</b>         | <b>00.00</b>          |
| <b>8</b>    | <b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>                            | 64,709,618.20        | 44,161,058.90         |
| <b>9</b>    | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>                     | <b>00.00</b>         | <b>64,709,618.20</b>  |
| <b>10</b>   | <b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>                    | <b>64,709,618.20</b> | <b>108,870,677.10</b> |

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

| <b>SORT_ID</b> | <b>ҮЗҮҮЛЭЛТ</b>                                  | <b>ТӨЛӨВЛӨГӨӨ</b> | <b>ГҮЙЦЭТГЭЛ</b> | <b>Дүн</b>      | <b>Хувь</b> |
|----------------|--|-------------------|------------------|-----------------|-------------|
| 1              | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | -                 | 64,709,618.20    | (64,709,618.20) | -           |
| 2              | I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН             | 557,912,800.00    | 449,037,134.00   | 108,875,666.00  | 80.4        |
| 3              | УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН                               | 557,912,800.00    | 449,037,134.00   | 108,875,666.00  | 80.4        |
| 4              | Бараа, үйлчилгээний зардал                       | 557,912,800.00    | 449,037,134.00   | 108,875,666.00  | 80.4        |
| 5              | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил                | 399,490,500.00    | 304,588,715.94   | 94,901,784.06   | 76.2        |
| 6              | Үндсэн цалин                                     | 268,949,500.00    | 200,196,060.41   | 68,753,439.59   | 74.4        |
| 7              | Нэмэгдэл   | 120,219,500.00    | 93,921,204.19    | 26,298,295.81   | 78.1        |
| 9              | Урамшуулал                                       | 10,321,500.00     | 10,471,451.34    | (149,951.34)    | 101.        |
| 11             | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл   | 49,936,400.00     | 38,482,035.16    | 11,454,364.84   | 77.0        |
| 12             | Тэтгэврийн даатгал                               | 33,956,700.00     | 26,636,728.74    | 7,319,971.26    | 78.4        |
| 13             | Тэтгэмжийн даатгал                               | 3,994,900.00      | 2,895,485.15     | 1,099,414.85    | 72.4        |
| 14             | ҮОМШӨ ний даатгал                                | 3,195,700.00      | 2,536,879.89     | 658,820.11      | 79.3        |
| 15             | Ажилгүйдлийн даатгал                             | 799,000.00        | 569,474.73       | 229,525.27      | 71.2        |
| 16             | Эрүүл мэндийн даатгал                            | 7,990,100.00      | 5,843,466.65     | 2,146,633.35    | 73.1        |
| 17             | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал        | 16,000,000.00     | 15,995,092.90    | 4,907.10        | 99.9        |
| 18             | Гэрэл цахилгаан                                  | 6,300,000.00      | 6,237,602.90     | 62,397.10       | 99.0        |
| 19             | Түлш, халаалт                                    | 8,200,000.00      | 8,200,000.00     | -               | 100.        |
| 20             | Цэвэр, бохир ус                                  | 1,500,000.00      | 1,557,490.00     | (57,490.00)     | 103.        |
| 30             | Нормативт зардал                                 | 57,445,300.00     | 54,990,790.00    | 2,454,510.00    | 95.7        |

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

|     |   |                |                |                 |      |
|-----|---|----------------|----------------|-----------------|------|
| 32  | Хоол, хүнс  | 57,445,300.00  | 54,990,790.00  | 2,454,510.00    | 95.7 |
| 34  | Эд хогшил худалдан авах                           | 15,000,000.00  | 15,000,000.00  | -               | 100. |
| 38  | Урсгал засвар                                     | 15,000,000.00  | 15,000,000.00  | -               | 100  |
| 43  | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр   | 852,900.00     | 852,900.00     | -               | 100. |
| 49  | Мэдээллийн технологийн зардал                     | 852,900.00     | 852,900.00     | -               | 100. |
| 53  | Бараа үйлчилгээний бусад зардал                   | 19,187,700.00  | 19,127,600.00  | 60,100.00       | 99.6 |
| 54  | Бараа үйлчилгээний бусад зардал                   | 16,629,100.00  | 16,569,000.00  | 60,100.00       | 99.6 |
| 55  | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх                 | 2,558,600.00   | 2,558,600.00   | -               | 100. |
| 97  | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР                    | 557,912,800.00 | 493,198,192.90 | 64,714,607.10   | 88.4 |
| 98  | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                           | 526,912,800.00 | 462,203,100.00 | 64,709,700.00   | 87.7 |
| 99  | Улсын төсвөөс санхүүжих                           | 462,203,100.00 | 462,203,100.00 | -               | 100. |
| 102 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих   | 64,709,700.00  | -              | 64,709,700.00   | -    |
| 103 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ                    | 31,000,000.00  | 30,995,092.90  | 4,907.10        | 99.9 |
| 104 | Орон нутгийн төсвөөс                              | 31,000,000.00  | 30,995,092.90  | 4,907.10        | 99.9 |
| 127 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл  | -              | 64,709,618.20  | (64,709,618.20) | -    |
| 128 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | -              | 108,870,677.10 | (108,870,677.1) | -    |
| 129 | ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ                  | -              | -              | -               | -    |
| 130 | БАЙГУУЛЛАГЫН ТОО                                  | -              | -              | -               | -    |
| 133 | АЖИЛЛАГСДЫН ТОО                                   | 22.00          | 22.00          | -               | 100. |
| 134 | Удирдах ажилтан                                   | 1.00           | 1.00           | -               | 100. |
| 135 | Гүйцэтгэх ажилтан                                 | 11.00          | 11.00          | -               | 100. |
| 136 | Үйлчлэх ажилтан                                   | 10.00          | 10.00          | -               | 100. |

## 5. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 402,175.5 мянган төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс 1,105.5 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 399,732.4 мянган төгрөгийн албан шаардлага хүргүүлж, 1,337.6 мянган төгрөгийн 1 зөвлөмж өгсөн.

### 5.1. Залруулга

Аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй болно.

### 5.2. Төлбөрийн акт

Тайлант онд ойн хандив цуглуулах, цасны баяр, Хөвсгөл нуур явах шатахууны зардалд нийт 1,105,500 төгрөг зарцуулсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т "үнэн зөв байх", Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2-т "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих" гэсэн заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

### 5.3. Албан шаардлага

Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй ажил олгогчоос төлөх НДШ-ийн зардлаас цалингийн зардал руу 617.7 мянган төгрөг зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, мөн Бараа үйлчилгээний бусад зардлаас албаны автомашингүй байж эдийн засгийн ангилал зөрчин 7,061.9 мянган төгрөгийн шатаж тослох материал худалдан авч зарцуулсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 392,052.8 мянган төгрөгийн, нийт 399,732.4 мянган төгрөгийн 3 зөрчилд албан шаардлага хүргүүлсэн.

### 5.4. Зөвлөмж

#### 1. Бусад хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал

##### Илрүүлэлт:

Тайлант онд ажиллагсадтай холбоотой авлага 1,208.1 мянган төгрөг, ажиллагсадтай холбоотой өглөг 129.5 мянган төгрөг, нийт 1,337.6 мянган төгрөгийн өглөг, авлага үүсгэж ажилласан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалттай нийцэхгүй байгаа ба "нийцсэн бөгөөд зохистой" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**Өгсөн зөвлөмж:** Ажил гүйлгээг гарахаас нь өмнө хянаж, өглөг авлага үүсгэхгүй ажиллах

Дээрх зөвлөмжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг аудитын тайлан хүлээн авсан өдрөөс хойш 30 хоногийн дотор гаргаж, зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 09 дүгээр сарын 20 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа |     | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан |     | Буруу тусган илэрхийлсэн |     | Үүнээс     |     |              |     | Зөвлөмж |     |
|-------------------|------------|-----|-----------------------------------|-----|--------------------------|-----|------------|-----|--------------|-----|---------|-----|
|                   | Тоо        | Дүн | Тоо                               | Дүн | Тоо                      | Дүн | Залруулсан |     | Залруулаагүй |     | Тоо     | Дүн |
|                   |            |     |                                   |     |                          |     | Тоо        | Дүн | Тоо          | Дүн |         |     |
| Дүн               |            |     |                                   |     |                          |     |            |     |              |     |         |     |

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

| Зөрчлийн товч утга                                       | Нийт зөрчил |                  | /мянган төгрөгөөр/ |          |          |                  |          |          |
|--|-------------|------------------|--------------------|----------|----------|------------------|----------|----------|
|  |             |                  | Төлбөрийн акт      |          | Үүнээс   |                  | Зөвлөмж  |          |
|  | Тоо         | Дүн              | Тоо                | Дүн      | Тоо      | Дүн              | Тоо      | Дүн      |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил |             |                  |                    |          |          |                  |          |          |
| Хугацаа хоцроож мэдээлсэн                                | 4           | 0                | 0                  | 0        | 1        | 392,052.9        | 0        | 0        |
| Мэдээлээгүй  | 26          | 392,052.9        | 0                  | 0        | 1        | 392,052.9        | 0        | 0        |
| <b>Дүн</b>   | <b>30</b>   | <b>392,052.9</b> | <b>0</b>           | <b>0</b> | <b>1</b> | <b>392,052.9</b> | <b>0</b> | <b>0</b> |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил                 |             |                  |                    |          |          |                  |          |          |
|  |             |                  | 0                  | 0        |          |                  | 0        | 0        |
| <b>Дүн</b>   |             |                  |                    |          |          |                  | 0        | 0        |
| <b>Нийт дүн</b>  | <b>30</b>   | <b>392,052.9</b> | <b>0</b>           | <b>0</b> | <b>1</b> | <b>392,052.9</b> | <b>0</b> | <b>0</b> |

**АУДИТЫН ТАЙЛАНГ**

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:  
 ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР *[Signature]* А.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:  
 АНХАН ШАТАНД ХЯНАСАН:  
 АУДИТЫН МЕНЕЖЕР *[Signature]* Б.ТЭГШДЭЛГЭР ОГНОО: 2/24  
 АУДИТОР *[Signature]* Г.ИЧИНХОРЛОО ОГНОО:  
 АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН *[Signature]* Д.АРИУНАА ОГНОО:  
 ЗАХИРАЛ ПАРТНЕР *[Signature]*  
 АРИ ФАЙНЭНС АУДИТ ХХК-ИЙН *[Signature]* Л.ПУНСАЛ-ОРЛОМ ОГНОО: 2024.02.23  
 ГЭРЭЭТ АУДИТОР *[Signature]*